

# ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫ

# ТЭМДЭГЛЭЛИЙН

# ДЭВТЭР

**БЭЛДЭЭРЭЙ!**

Чуулган эхлэхээс өмнө та хувийн илчлэлт эрэлхийлснээр Их Эзэний дуу хоолойг сонсоход бэлтгэж болно.

Би хувиараа залбирахад цаг гаргасан уу?

Би судруудаа уншсан уу?

**ЕРӨНХИЙ ЧУУЛГАНААС ИРЭХ ХУВИЙН ИЛЧЛЭЛТИЙН  
ҮНЭТ ЭРДЭНЭСИЙГ ТЭМДЭГЛЭН АВАХ ТАЛБАР**

# АСУУ,

Ахлагч Жэффри Р.Холланд  
“Илчлэлт ихэвчлэн үргэлж  
асуултын хариулт болон ирдэг”<sup>1</sup>  
гэж заасан.

## ТЭГЭЭД СОНС

Ерөнхий чуулган бол Их Эзэний таныг мэдэж аваасай, хийгээсэй гэж хүссэн зүйлсийг мэдэж авах гайхалтай боломж юм. Гэхдээ Түүнийг тантай ярьж байгаа гэдгийг та яаж мэдэх вэ? Энэ нь өөрийн амьдралын тухай болон танд ямар тусламж хэрэгтэй байгааг бодохоос эхэлдэг.

Дараах асуултуудын талаар бодож үзэж болох юм. Үүнд:

Чуулганы үеэр Их Эзэн ямар хувийн удирдамж өгөөсэй гэж бодож байгаагаа бичих цаг гарга.

Ерөнхий чуулганыг сонсож байхдаа дээрх асуултуудыг сана. Их Эзэн танд хувь хүн рүү чиглэсэн удирдамж өгч чадна.

Би одоо хийж байгаа ямар зүйлээ болих хэрэгтэй байгаа вэ?

Тулгараад байгаа асуудлаа би хэрхэн шийдвэрлэж чадах вэ?

Ирээдүйд би юунд бэлтгэлтэй байх хэрэгтэй вэ?

Би Христийн ямар зан чанарыг хөгжүүлэхээр ажиллаж чадах вэ?

Одоо хийж эхлэх хэрэгтэй юуг би хийгээгүй байна вэ?



## ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛ

Хүмүүс чуулганаар олон шалтгаанаар тэмдэглэл хөтөлдөг. Тэмдэглэл хөтлөх нь анхаарлаа сайтар төвлөрүүлж, сонссон зүйлсээ санахад тусална. Та тэмдэглэл хөтөлснөөр хувийн илчлэлт хүлээн авч, үүний дагуу үйлдэхэд бэлэн байгаагаа Их Эзэнд харуулдаг.

Оролдоод үзээрэй! Чуулганыг сонсож байхдаа, үг хэлэгчийн үгийг нэг бүрчлэн бичих гэж санаагаа бүү чилээ. Хэрэв та ямар нэгэн зүйлийг сайн сонсож чадалгүй өнгөрүүлсэн бол дараа нь үргэлж дахин сонсох, унших эсвэл үзэх боломжтой. Үг хэлэх үеэр өөрт төрсөн бодол, сэтгэгдлийг бичиж авахад анхаар. Хэрэв та тэр даруй бичээд авчихвал, дараа нь санах гэж хичээх шаардлагагүй болно.

Тэдний хэлсэн зүйл:

Надад төрсөн мэдрэмж, сэтгэгдэл:

Тэмдэглэл хэрхэн хөтлөх талаар зөвлөгөө хэрэгтэй байна уу? Зарим зөвлөгөөг санал болгоё. Үүнд:

“Би чуулганы үеэр тэмдэглэл хөтлөхдөө үг хэлэгчийн юу хэлж буйг яг таг бичих бус, харин Сүнснээс надад өгөгдөж буй хувийн заавруудыг бичиж авдаг. Хэлж буй зүйлс нь бидний сонсож, мэдэрч байгаа зүйлтэй адил чухал байдаггүй.

Ахлагч Робэрт Д.Хэйлс (1932–2017)<sup>2</sup>

Тэдний хэлсэн зүйл:



**ОНЦГОЙ УРИЛГА**

Сүмийн удирдагчид сүнслэг байдлын хувьд өсөж хөгжихөд маань туслах урилгыг олонтоо өгдөг. Та хуралдааны үеэр ямар нэгэн тодорхой урилга сонссон уу? Эдгээрийг мартахгүйн тулд энд бичээрэй!



Надад төрсөн мэдрэмж, сэтгэгдэл:



**ТҮР ЗОГС!**

Та одоогоор асуултдаа хариулт авчихсан байна уу? Хэрэв авсан бол хүлээн авсан удирдамж, чиглэлээ бичиж авах цаг гарга.



"Та энэ Ерөнхий чуулган дээрх захиасуудаас Их Эзэний дуу хоолойг сонсож, эдгээр сүнслэг өдөөлтийн дагуу үйлдсэнээр өөрийнхөө дээр буй тэнгэрийн нөлөөллийг мэдэрч, таны болон таны эргэн тойрны хүмүүсийн амьдралыг адислах болно гэдгийг би амлаж байна."

Ахлагч Нийл Л.Андэрсэн<sup>3</sup>



“Ерөнхий чуулганы хамгийн агуу адислалууд тухайн чуулган дууссаны дараа бидэнд ирдэг. Судруудад тогтмол дурдагддаг, бид Их Эзэний үгсийг сонсохын тулд цугларч, тэдгээрийн дагуу амьдрахын тулд гэр гэртээ буцдаг гэсэн загварыг санагтун.”

Ахлагч Роберт Д.Хэйлс<sup>4</sup>



Тэдний хэлсэн зүйл:



Надад төрсөн мэдрэмж, сэтгэгдэл:



**ТҮР ЗОГС!**

Та амьдралаа сайжруулахын тулд үргэлжлүүлэн хийх, хийхээ болих эсвэл хийж эхлэх ёстой зүйлийнхээ талаар өөр санаа авсан уу?



**ОНЦГОЙ УРИЛГА**

Сүмийн удирдагчид сүнслэг байдлын хувьд өсөж хөгжихөд туслах урилгыг олонтоо өгдөг. Та хуралдааны үеэр ямар нэгэн тодорхой урилга сонссон уу? Эдгээрийг мартахагүйн тулд энд бичээрэй!

# БИ ДАРАА НЬ ЯАХ ВЭ?

Төлөөлөгч, бошиглогчдын гэрчлэлийг сонсох нь ямар гайхалтай туршлага болдог гээч! Та амьдралд тань тус болох удирдамжийг хүлээн авсан уу?

Сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүлэхэд туслах зорилго тавих тохиромжтой цаг нь яг одоо юм. Санаа авч болох зарим жишээг өгье. Үүнд:

- Өөрийн хүлээн авсан, хувь хүнд хандсан нэгээс хоёр удирдамжийг сонгон авч, үйлдэх төлөвлөгөө гарга.
- Нэг асуудал дээр юм уу сонссон урилга дээрээ ажиллах төлөвлөгөө гарга.
- Өглөө болгон хичээлдээ явахаар бэлтгэхдээ нэг чуулганы үг сонсоорой.
- Чуулганаас таалагдсан түүх, эшлэлээ найзтайгаа юм уу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хуваалц.
- Чуулганы үеэр өөрсдийнх нь сэтгэлийг хөндсөн зүйлсийг хуваалцах цагийг гэр бүлээрээ төлөвлө.
- Танд өөр ямар нэгэн санаа төрж байна уу? Зорилгоо бичихдээ:

---



---



---



---

Энэ хуудасны энэ хэсгийг хайчилж ав. Дараа нь зорилгоо санаж байх зорилгоор өдөр бүр харах боломжтой газарт үүнийг байрлуулж болно!





Та нарын тодорхой залбирлуудын хариулт тодорхой нэг хэлсэн үг эсвэл өгүүлбэрээс ч шууд ирж болно. . . . Зөвлөгөөний үгийг сонсох, дагахыг чин сэтгэлээсээ хүсэх нь хувийн илчлэлтийн замыг бэлтгэх болно.”

Ахлагч Дийтр Ф.Угдорф<sup>5</sup>

### Эшлэл

1. Jeffrey R. Holland, “Cast Not Away Therefore Your Confidence,” *Ensign*, Mar. 2000, 9.
2. Робэрт ДХэйлс, 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган (*Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 11-р сар, 6).
3. Нийл Л.Андэрсэн, (*Ensign*, Nov. 2017, 126 эсвэл 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 130).
4. Робэрт ДХэйлс, 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган (*Ensign* эсвэл *Liahona*, 2013 оны 11-р сар, 7).
5. Дийтр Ф.Угдорф, “Ерөнхий чуулган—Энгийн адислал гэж байдаггүй,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 9-р сар, 4.

© 2022 Intellectual Reserve, Inc.


Бүх эрх хамгаалагдсан.

ХУВИЙН БОЛОН АРИЛЖААНЫ БУС ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН УГ ТОВХИМЛЫГ ДАХИН ХЭВЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ӨГЧ БОЛНО. ТОЙРГИЙН УДИРДАГЧИД ӨӨРСДИЙН ДУУДЛАГЫН ХҮРЭЭНД, ҮЙЛЧИЛЖ БҮЙ ХҮМҮҮСТЭЭ ЗОРИУЛАН ЦӨӨН ТООГООР ХЭВЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ӨГӨХ НЬ ҮҮНД БАГТАНА. УГ ТОВХИМЛЫГ БҮХЭЛД НЬ ХЭВЛЭХ ЁСТОЙ. ЭНЭХҮҮ ЗӨВШӨӨРӨЛ НЬ УГ МАТЕРИАЛЫГ ОНЛАЙН ДЭЭР БАЙРШУУЛАХ, ӨӨР ЗОРИЛГООР АШИГЛАХ, ТҮГЭЭХТЭЙ ХАМААРЛГУЙ БОЛНО. УГ МАТЕРИАЛЫГ ӨӨР ЗОРИЛГООР АШИГЛАХ БОЛ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ШААРДЛАГАТАЙ.

permissions.  
ChurchofJesusChrist.org

## ӨӨР ХУВЬ ХЭРЭГТЭЙ ЮУ?

Энэхүү тэмдэглэлийг  
[conference.ChurchofJesusChrist.org](https://conference.ChurchofJesusChrist.org)  
хаягаар татан авч хэвлэнэ үү.



ЕСУС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН  
СҮМ